



ЖИЛИЙН
ТАЙЛАН | 2021

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН

ОСОЛ

0



АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК	10
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ	12
АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО	17
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	18
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ	22
ХҮНИЙ НӨӨЦ	28
БАЙГАЛЬ ОРЧИН ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ	32
ОРОН НУТАГ ХАМТЫН АЖИЛЛАГАА	36
КОВИД-19 МЭДЭЭЛЭЛ	38
ХЭМНЭЛТ 2021	41
АУДИТЫН ТАЙЛАН	43

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Өнгөрч буй онд дэлхий нийтэд тархсан ковид-19 цар тахлын улмаас улс эх оронд минь эдийн засаг, эрүүл мэндийн хувьд амаргүй жил байлаа, гэсэн хэдий ч Багануурын уурхайчид бид улс орноо эрчим хүчний нүүрсээр тасралтгүй хангаж, осол зөрчилгүй ажиллах үндсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр Японы олон улсын хамтын ажиллагааны банкны 12,5 сая долларын хөнгөлөлттэй зээлээр 12 ширхэг техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр бид 2021 онд 19,8 сая.м³ хөрс хуулж, 4,3 сая тн нүүрс олборлон, борлуулж төлөвлөгөөт зорилтоо 101 хувиар давуулан биелүүлж ажилласан.

Уул уурхайн салбартаа анхдагч болж хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллагаар батламжлагдсан. Ингэснээр компанийн үйл ажиллагаа, менежментийн тогтолцоо сайжирч нийт ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэг дээшилж вешион зеро буюу ослыг тэглэхэд томоохон алхам болж нэн тэргүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал зорилтоо биелүүлэх суурь болж байна.

Уулын ажлын төлөвлөлтийг оновчлох, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх, борлуулалтыг нэмэгдүүлэх зэрэг ашигтай шийдлүүдийг урьдчилан тооцоолсон 2022–2027 он хүртэл дунд хугацааны техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулсан.

Хэдийгээр өнгөрсөн онд цар тахлын амаргүй цаг үе байсан боловч уурхайчдынхаа амьдралын баталгаа болсон орлогыг тасалдуулахгүй байж ажлын

байраа хадгалж чадсан маань Монгол Улсын ТОП-100 ААН, дүүргийн 2021 оны тэргүүний ААН-ээр шалгарахад нөлөөллөө.

Мөн уул уурхайн салбартаа анхны нөхөн сэргээлт хийсэн Багануурын уурхай – уур амьсгалын өөрчлөлт түүний нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 1 сая мод тарих санамж бичгийг үзэглэлээ.

Ийнхүү бид өнгөрсөн хугацаанд дэд бүтэц, стратегийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, зардал хэмнэх олон ажлуудыг хийж, тухайлбал ЭШ – 10/70 экскаваторын шанага үйлдвэрлэлийн ажлуудаа хийж, цаашид илүү тогтвортой хөгжих сууриа тавьж, олон улсын стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахаар эхэлсэн.

Ирэх ондоо бид өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашигтай ажиллах чиглэлээр хичээн ажиллах болно.

Бидэнтэй хамтарч ажилласан Салбарын яам, Эрдэнэс Монгол ХХК, Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Багануур дүүргийн төр захиргааны байгууллагууд болон байнгын харилцаатай хамтрагч байгууллагууд та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, ажлын өндөр амжилтыг хүсье.

Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх захирал


Э.Номинчулуун

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



1978 ОНД БАЙГУУЛАГДСАН



ТЭЭВЭРТЭЙ ТЭЭВЭРГҮЙ
ХОСОЛСОН АШИГЛАЛТЫН
СИСТЕМ



75.00% “ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК
21.06% МОНГОЛИАН КОАЛ
КОРПОРЕЙШН
3.94% ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НҮҮРСНИЙ ИЛЧЛЭГИЙН
СТАНДАРТ 3360 ККАЛ/КГ




НӨӨЦ 783.0 СЯ ТОНН



ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ
4.0 СЯ ТОНН



1139 АЖИЛТАНТАЙ




Багануур ХК

Монгол улсын эрчим хүчний нүүрсний 60%-ийг хангадаг




60%



Багануур ХК

Улс орнуудын эрчим хүчний үнэ



Эрчим хүчний нүүрсний үнэ



150₮

33,5 ₮


29,1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
ТЕХНИКИЙН ӨРГӨТГӨЛ
ХИЙЛЭЭ






ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК


ХӨРС ХУУЛАЛТ (МЯН.М³)




ХӨРС ХУУЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ




ӨРӨМДЛӨГИЙН АЖИЛ (МЯН.МЕТР)




ТЭСЭЛСЭН УУЛЫН ЦУЛ (МЯН.М³)




НҮҮРС БОРЛУУЛАЛТ (МЯН.ТН)




НҮҮРСНИЙ ДУНДАЖ ИЛЧЛЭГ (ККАЛ.КГ)




ТАТВАР ХУРААМЖ (ТЭРБУМ.ТӨГ)




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ (МЯН.ТӨГ)




ТЕХНИК АШИГЛАЛТЫН КОЭФФИЦЕНТ




УС ШҮҮРҮҮЛЭЛТ (МЯН.М³)



АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ



СУРГАЛТАД ХАМРАГДСАН АЖИЛТНЫ ТОО



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахлын улмаас хүндэрсэн эрсдэл өндөр жил болж өнгөрсөн хэдий ч “Багануур” ХК-ийн хамт олны хүчин зүтгэл, хариуцлага, оновчтой зохион байгуулалтын үр дүнд төлөвлөсөн ажлаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадсан, хөгжлийн түүхэнд бодитоор бичигдэн үлдэх жил болж өнгөрлөө.


“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд Монгол улсын Засгийн газрын бодлого, чиглэлтэй уялдуулан уурхайн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг дэмжин ерөнхий удирдлагаар ханган, компанийн засаглал, хөгжлийн стратеги хэрэгжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Монгол Улсын төвийн бүс тэр дундаа нийслэл Улаанбаатар хотын эрчим хүч, дулаан хангамжийн системд томоохон хувь нэмэр оруулан ажиллаж байгаа “Багануур” ХК-ийн үйл ажиллагааг толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн зүгээс дэмжин техник, технологийн шинэчлэлийг хамтран хэрэгжүүллээ.

“Эрдэнэс Монгол” ХХК болон охин, хараат компаниудын нэгдлийн хүрээнд бид цаашид дэлхийн жишигт нийцсэн уул уурхай, дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай уул уурхайг бэхжүүлэх, зохистой өгөөжийн түвшинг ханган бизнесийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэн ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхний ажил үйлсэд өндөр амжилт хүсэж, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

БАГАНУУР ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.БАТСАЙХАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.БАТСАЙХАН

Нүүрс, эрчим хүч, хийн төсөл хөтөлбөр хариуцсан захирал, “Эрдэнэс Монгол” ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Д.БАЛЖИННЯМ

Хүний нөөцийн удирдлагын газрын дарга,
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын захиргаа

М.ОТГОНБАЯР

Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн төлөөлөл

М.ЦЭНГЭЛ

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга,
“Эрдэнэс Монгол” ХХК

Д.ЧИНБАТ

Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн төлөөлөл

Г.НАНДИНЖАРГАЛ

Төрийн нарийн бичгийн дарга,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Б.ОЧБАДРАХ

Хараат бус гишүүн, “Монгол эрмэлзэл” ТББ-ийн тэргүүн

Г.ЗОЛБОО

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Сангийн яам

С.ЭНХТАЙВАН

Хараат бус гишүүн, “Монголиан транс ложистик” компанийн хуулийн хэлтсийн дарга

Д.ДАВААСҮРЭН

Эрчим хүч, түлшний бодлогын хэрэгжилтийн газрын түлшний хангамжийн хэлтсийн дарга,
Эрчим хүчний яам

Б.ОСОРГАРАВ

Хараат бус гишүүн, “Грант торнтон аудит” ХХК-ийн ерөнхий захирал

Д.ОТГОНБАТ

Хараат бус гишүүн, “Өмгөөллийн дэнс легал” ХХН-ийн захирал





2021 ОНД ТҮҮХЭНДЭЭ
ХАМГИЙН ИХ БОРЛУУЛАЛТ

4.3 САЯ ТОНН
НҮҮРС



КОМПАНИЙН ТУХАЙ

"Багануур" ХК нь анх 1978 онд 200.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай "Багануурын нүүрсний түр уурхай" нэртэйгээр гараагаа эхэлж, эдүгээ 43 дэх жилдээ ажиллаж байна. Монгол улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувь, төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 70 хувийг дангаараа хангадаг нүүрсний ил уурхай юм.

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналтын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4–5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3 давхаргаас бүрдэнэ. Багануурын нүүрс нь эрчим хүчний зориулалттай Б2 маркийн нүүрсэнд хамаарна. Нүүрсний үнслэг нь 12–17%, ЧИЙГЛЭГ нь 28–33%, хүхрийн агуулга нь 0.4%, дулаан , гаргах илчлэг нь 3200–3600 ккал/кг.

1978 онд баталсан тооцоогоор нүүрсний нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан хайгуул хийж ордын баялаг нөөцийг 708.2 сая.тн болгосон. 2014–2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдэж балансын НӨӨЦИЙГ 280,0 сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн НИЙТ 812,0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.



АЛСЫН ХАРАА


Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

ҮНЭТ ЗҮЙЛ



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Бид хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг.



САНААЧЛАГЧ, БҮТЭЭЛЧ, СУРАЛЦАГЧ

Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан санаачилгатай байж шинэ шийдэл ажлын шинэ арга замыг бүтээлчээр хөгжүүлж мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулахын тулд мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлдэг.



ШУДАРГА ҮНЭНЧ

Бид зөв зүйлийг хийж, шударга ил тод байдаг. Өөртөө болон бусад зарчимч байдлаар хандаж шударга бус байдалтай үл эвлэрнэ.



ХАРИУЦЛАГА

Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж хийж буй үйлдэл хэлсэн үгэндээ эзэн болдог.




БАГИЙН АЖИЛЛАГАА, ХАМТЫН ХҮЧ

Бид харилцан итгэлцэл хүндлэлийг бий болгон хүн бүр багийн нэг хэсэг болж үр дүнтэй хамтран ажилладаг.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн бүтэц зохион байгуулалтыг ТУЗ-ийн 2020 оны 27 дугаартай тогтоолоор баталсан “Бизнес төлөвлөгөө батлах тухай” тогтоол болон Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/02 дугаартай тушаалаар тус тус баталж, 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1139 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



КОМПАНИЙН УДИРДЛАГА

Э.НОМИНЧУЛУУН

Гүйцэтгэх захирал

Д.ТҮВШИНЖАРГАЛ

Тэргүүн дэд захирал

Х.ХАШБАТ

Техникийн бодлогын хэлтсийн дарга

Н.БАЗАРСҮРЭН

Үйлдвэр технологи эрхэлсэн дэд захирал

Ч.НАРАНБАТ

Технологийн бодлогын хэлтсийн дарга

П.ЭРДЭНЭЦОГТ

Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал

Б.БАТБОЛД

Захиргаа хүний нөөц удирдлагын хэлтсийн дарга

Ж.БАЖУНА

Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал

Д.БОЛД

Санхүү эдийн засаг бодлогын хэлтсийн дарга

Д.ГАНЗОРИГ

Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

С.БАТХИШИГ

Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга

А.ЭНХБОЛД

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтсийн дарга

Ц.ЭНХБАТ

Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга



**ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ
МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
МЕНЕЖМЕНТИЙН
ТОГТОЛЦООНЫ**

MNS  45001:2018

**ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГААР
БАТЛАМЖЛАГДЛАА**



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

БОДЛОГО БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Багануур ХК нь ХАБЭА-н хуулийн заалтыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг аюулгүй явуулах, ажилтнаа хамгаалах зорилгоор ХАБЭА-н удирдлагын тогтолцооны олон улсын стандартын хүрээнд ХАБЭА-н бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна.



ГҮЙЦЭТГЭЛ 100%

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай компани 2021 онд 6 зорилтын хүрээнд 21 заалттай төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан, төлөвлөгөөний биелэлт 100%, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны OHSAS 18001:2012 стандартаас ISO 45001:2018 стандарт руу шилжүүлэх ажлыг судлан, бэлтгэлийг хангаж, бодлого, зорилт, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан, журам, заавруудын шаардлагатай хэсгүүдийг шинэчлэх, шинээр боловсруулах, гүйцэтгэлийн хэмжилт мониторинг, аудитыг хэсэг нэгжүүдийг хамруулан хийх, удирдлагын дүн шинжилгээний хурлыг журмын дагуу хийсэн.

Компанийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хэмжилт мониторингийг 2021 оны 5-р сард компанийн ИТА-даас бүрдүүлсэн багаар бүх хэсэг нэгжийг хамруулан хийлгэсэн.

Мониторингийн үнэлгээг 5 чиглэл, 35 үзүүлэлтээр дүгнэн, эрсдэлийн түвшинг тооцсон.

Нэгдсэн үнэлгээгээр 15 оноо авахаас 13,7 оноо 92%-тай, эрсдэлийн түвшин “БАГА”, цаашид “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” гэж гарсан. Энэ нь өмнөх гүйцэтгэлийн хэмжилт мониторингийн дүнтэй харьцуулахад 10.1%-иар өссөн, ерөнхий үнэлгээ 80-аас дээш хувьтай гарсан тул хэрэгжүүлж буй ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо, түүний хяналт үр дүнтэй байгааг харуулсан.

“Багануур” ХК Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 Олон Улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллагаар батламжлагдсан.

Францын Олон Улсын аудитын “Афнор” групп Багануур ХК-д ISO 45001:2018 стандартын баталгаажуулалтын гэрчилгээг олгосон.

Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO 45001:2018 стандартын гэрчилгээг авснаар компанийн үйл ажиллагаа, менежментийн тогтолцоо сайжирч нийт ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэг дээшилж vision zero буюу ослыг тэглэхэд томоохон алхам болж буй юм.

Баталгаажуулалтын гэрчилгээг авах нь стандартыг нэвтрүүлэх ажлын эхлэл бөгөөд цаашид жил бүр стандартын хэрэгжилтээ шалгуулж, баталгаажуулж байх юм.



2.2 САЯ ХҮН ЦАГ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

ХАБЭА-н сургалтыг Хөдөлмөрийн сайдын 2019 оны А/370 тоот тушаалд заасан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу 9 үндсэн, 34 дэд сэдвийн хүрээнд 12 цагийн багтаамжтай хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтын түвшин тогтоох шалгалтад давхардсан тоогоор 1855 ажилтан хамрагдахаас 1803 ажилтан хамрагдсан, хамрагдалт 97.1%-тай.


Мөн ХАБЭА-н ажилтны чадамжийн гэрчилгээний хугацаа нь дууссан 42 инженер техникийн ажилтныг

“Ололт Амжилт” ХХК-ийн сургалтын төвөөс зохион байгуулсан “ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан” бэлтгэх онол, практикийн 40 цагийн сургалтад хамруулж чадамжийн гэрчилгээг сунгуулсан.




СУРГАЛТАНД 1803 АЖИЛТАН

СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ



ХАБЭА-Н ШАЛГАЛТ, ЧАНАР



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ ҮЗЛЭГ

Ажилтнууд ажил эхлэхийн өмнө ажлын байр, орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд үзлэг хийж илэрсэн зөрчлийг аюулыг мэдээлэх хуудас, утсыг ашиглан мэдээлэх, мэдээллээр ирсэн зөрчлийг нэн даруй арилгах үүргийг ХАБЭАХ-ээс холбогдох албан тушаалтанд өгч, биелэлтийг 7 хоног бүрийн үйлдвэрийн шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажилладаг.


ХАБЭА-н ээлжит үзлэгийг 4 удаа хийж, давхардсан тоогоор 115 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оноос

16.6%-иар өссөн, зөрчил арилгах 64 албан шаардлагыг хэлтэс, хэсэг, нэгжийн удирдлагад өгч, илэрсэн зөрчлийн 98%-ийг бүрэн арилгуулсан.


Ээлжит бус үзлэгийг нийт 145 удаа хийж, 399 зөрчлийг илрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 0.5 дахин өссөн.

2021 онд осолд дөхсөн 6 тохиолдол гарсны 3 нь хөнгөн гэмтэл, 3 нь техник ашиглалтын зөрчил байсан, өмнөх оноос осолд дөхсөн тохиолдлын тоо, техник ашиглалтын зөрчлийн тоо буурсан.


МЭДЭЭЛСЭН АЮУЛ ЭРСДЭЛИЙН ТОО, АРИЛГАЛТЫН ХУВЬ




ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДОЛ




ЭЭЛЖИТ ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, АРИЛГУУЛСАН ХУВЬ



ЭЭЛЖИТ БУС ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, АРИЛГУУЛСАН ХУВЬ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ





АЖИЛТАН БҮР БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ
АМЖИЛТ БҮХЭН ТЭДЭНТЭЙ ХАМТ ...



ХҮНИЙ НӨӨЦ



ЭРҮҮЛ УУРХАЙЧИН

Өв тэгш бие бялдартай, эрүүл зохистой хооллолттой, амьдралын зөв дадалтай эрүүл уурхайчныг хувь хүний оролцоо, байгууллагын дэмжлэгтэйгээр төлөвшүүлэх зорилгын хүрээнд 2021 онд “Эрүүл уурхайчин” хөтөлбөрийн төлөвлөгөө гарган Хөдөлгөөн, Эрүүл хооллолт, Эрүүл мэнд гэсэн 3 үндсэн чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллалаа. Жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нараар ердийн болон МШӨ-с урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгийг хийлгэж 947 ажилтан хамрууллаа. Ажилтнуудын хувьд нийтлэг зүрх судасны өвчлөл зонхилж байна. Үүнтэй холбогдуулан компанийн хэмжээнд ажилтнуудад зөв зохистой хооллолтын өдөрлөгүүдийг зохион байгуулж, хоолны давсны хэрэглээг 25–30% бууруулсан. Мөн “Хотын соёл” аянд нэгдэн эрүүл мэнд-хөдөлгөөний хүрээнд нийтдээ давхардсан тоогоор 754 ажилтан хамтдаа өдөр бүр 4 км алхалт хийлээ.

БОЛОВСРОЛТОЙ УУРХАЙЧИН


2021 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөг өнгөрсөн оны гүйцэтгэлээс хамаарч сургалт хөгжлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан гаднын байгууллага болон дотоод сургалтуудыг төлөвлөн ажилласан. Ковид-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэмтэй байсан тул танхимын сургалт зохион байгуулагдаагүй цахим хэлбэрээр сургалтыг хийсэн. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 3764 ажилтан дунджаар 10.8 цагийн сургалтад хамрагдаж нийт 43,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.





ЗӨВ ҮЗЭЛ ХАНДЛАГАТАЙ УУРХАЙЧИН

Ажилтнуудаас байгууллагын соёл, сэтгэл ханамжийн судалгааг үнэнч байдал, байгууллагын зорилго зорилтоо хэрхэн ойлгож түүнд хувь нэмрээ хэрхэн оруулдаг, байгууллагынхаа соёлыг удирдах болон гүйцэтгэх түвшинд хэрхэн хардаг, мөн ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох, сэтгэл ханамжид нөлөөлөгч гол хүчин зүйлсийг нарийвчлан судлахад түүвэр байдлаар тоон болон чанарын судалгааг хийсэн. Тус судалгааны үр дүн Сэтгэл ханамжийн үзүүлэлт дээр чухалчлах байдал болон сэтгэл ханамжид үзүүлэх нөлөөлөл өндөртэй хэдий ч сэтгэл ханамж дундаж түвшинтэй байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХТАЙ УУРХАЙЧИН

Багануур ХК болон үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороотой байгуулсан хамтын гэрээний 4.3.16 дахь заалтын дагуу нийт 87 ажилтанд 125 сая төгрөг, 4.3.11 дэх заалтын дагуу 36 ажилтанд рашаан сувиллын хөнгөлөлт, 4.3.16.7 дэх заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарахаар хөдөлмөрийн гэрээ цуцалж байгаа 70 ажилтанд 3,2 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олголоо.



ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ




Боловсролын түвшин

30% Дээд
10% Тусгай дунд
54% Бүрэн дунд
6% Бүрэн бус дунд




Насны ангилал

18–23 нас 4%
24–39 нас 49%
40–55 нас 43%
56–60 нас 4%



Ажилласан жил /хувиар/

0–5 жил 27%
6–15 жил 42%
16–с дээш жил 31%




Жендер

Эрэгтэй – 86%
Эмэгтэй – 14%

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО

Ажилтнуудын сайн дурын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороотой бөгөөд жил бүр хамтын гэрээ байгуулан ажилладаг.

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН НЭГДСЭН ХОРООТОЙ БАЙГУУЛСАН ХАМТЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ





1,000,000
МОН




БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, байгаль орчинг хамгаалах, дүйцүүлэн хамгаалал, тэрбум мод үндэсний хөтөлбөр зэрэг олон ажлуудыг хийгээд байна.

Жил бүрийн байгаль орчныг хамгаалах ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр боловсруулж БОАЖЯ-аар батлуулан төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн байгаль орчны газраас комисс томилогдон шалган дүгнэж байна.




АГААРЫН ЧАНАР

Агаар дахь бохирдуулагч бодис /азотын давхар исэл NO₂, хүхрийн давхар исэл SO₂/-ын шинжилгээг БОХЗТЛабораторитой гэрээ байгуулан улирал бүр 6 цэгт хийлгэсэн. Шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ стандартаас хэтрээгүй байна. Тоосжилтын хэмжилтийг 6 цэгт 2 сар тутам хийхээр төлөвлөн хийсэн. Орчны тоосжилтыг агаарын

чанарын индексээр үнэлэхэд: 1-р сард дүүргийн төв, 11-р сард задгайн хэсэгт стандарт түвшингээс бага зэрэг хэтэрсэн бага зэргийн бохирдолттой байна. 1-р сарын хэмжилтээр дүүргийн задгай хэсэгт стандарт түвшингээс их буюу дунд зэргийн бохирдолттой гарсан. Бусад цэгүүдэд стандарт түвшинд хэвийн байна.

Агаарын чанар:




УС ШҮҮРҮҮЛЭЛТ, УСНЫ ЧАНАР

Уурхай жилд 5.0–5.5 сая.м3 усыг шүүрүүлдэг үүнээс Багагүн нуур, Хужирт, Хуцаа голуудыг тогтмол тэжээдэг. 2021 онд 5,178,300 м3 усыг шүүрүүлж Багануур дулааны станцад 207.7 мян. м3,

Гол голдирол нуур тэжээхэд 1832.5 мян.м3, уурхайн замын тоосжилт дарах, мод услах, нүүрсний гал дархад 1143 мян.м3 ус зарцуулсан байна.

Цутгасан усны хэмжээ мян.м3



ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хөрснөөс нийт 28 удаа дээж авч агрохими, хүнд металл, нефтийн агууламжийг БОХЗТЛ-иор тодорхойлуулсан. Шинжилгээгээр хөрсний хүнд металлын агууламж хэвийн, агуулахад хадгалагдаж байгаа шимт хөрсний ялзмагийн агууламж 0.6–7.4-ийн хооронд байна.

Шимт хөрсийг хадгалахдаа "MNS 5916:2008" Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт

стандартын дагуу 5м-ээс ихгүйгээр өндөртэйгөөр байгуулан ургамалжуулан хадгалж байна. 2021 онд нийт 33,98 га талбайгаас 102 мян.м3 шимт хөрсийг хуулж хадгалсан.

Тос тосолгооны материалаар бохирдсон хөрсийг хөрс саармагжуулах талбайд буулган саармагжуулсан. Саармагжуулалтад бууц болон био бэлдмэл ашиглан хольж саармагжуулан хадгалж байна.



УРГАМАЛ АМЬТАН

Ургамлан нөмрөгийг тодорхойлох, ургамлын өндөр, тусгаг бүрхцийг тодорхойлсон. Судалгааны явцад уурхайн орчимд нийт 24 овгийн 49 төрлийн 57 зүйл ургамал тэмдэглэгдлээ. Үүнд: Үетэн, нийлмэл цэцэгтэн, буурцагтан, холтсон цэцэгтэн, сарнайн овгууд голлох байр эзэлж байна.

Хөхтөн амьтны зүйлийн бүрдлийг гаргавал. Үүнд: шавьж идэштний багт 1 зүйл, гар далавчтаны багт 3 зүйл, туулай хэлбэртний багт 2 зүйл, мэрэгчтний багт 6 зүйл, махчтаны багт 5 зүйл, туруутны багт 1

зүйл, нийт 18 зүйл хөхтөн, 282 зүйлийн шувуу, 2 зүйл хоёр нутагтан, 1 зүйлийн гүрвэл, 2 зүйл могой тус тус тэмдэглэгдсэн байна.

Хөхтөн амьтдаас олон улсын хэмжээнд ховордож болзошгүй зүйл 1, “анхааралд өртөхөөргүй” 17 зүйл тус тус тэмдэглэгдсэн байна. Мөн бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” зүйл 2, “ховордож болзошгүй” зүйл 4, “мэдээлэл дутмаг” 2 зүйл, “анхааралд өртөхөөргүй” 10 гэж тус тус үнэлэгдсэн.

НӨХӨН СЭРГЭЭЛТ


Уулын ажлын онцлогоос хамааран уулын ажлын эцсийн хүрээ хязгаарын дагуу овоолгууд хэлбэржээгүй, нөхөн сэргээсэн талбай бэлэн бус тул нөхөн сэргээлтийн оронд 0,5 га талбайд ойжуулалт хийсэн. Ойжуулалтад 1200ш нарсны суулгацыг тарьж, мал ордог хэсгүүдийг хашиж тор татсан.

Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор УШХ-ийн гадна 560ш, Хэрлэн голын эрэгт 100ш, дүүрэгт 500ш, дугуйн замын нөхөн тариалтад 30ш мод бутыг тарьсан. 2021 оны хаврын мод тариалтад 1190ш мод бутыг тарьсан.

ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлыг “Багануур тохижилт” ОНӨААТҮГ, Татварын албатай гурвалсан гэрээг байгуулан дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хаяж байна.

Дахивар хог хаягдлыг дүүргийн ангилах цэгт тушааж байна. Үйлдвэрийн хог хаягдлыг ангилан хадгалж байна.





Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн ажилчид “Нэг ажилтан нэг мод” аян өрнүүлж намрын тарилтаар 1155 ш мод бутыг тарьсан.



ОРОН НУТАГ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодексийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт зааснаар Бaganуур дүүргийн Төр захиргааны байгууллага, “Багануур” ХК-ийн хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг зурж, дүүрэгтэйгээ хамтран ажиллаж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Дүүргийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг ханган ажиллаж буй ДОК, Эрүүл мэндийн төвийн хамт олонд уурхайчид бид 500 ширхэг түргэвчилсэн оношлуур, маск, дархлаа дэмжих 11,4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг хүлээлгэж өгөв.



Цар тахлын үед эмнэлгүүдэд хүчилтөрөгчийн хэрэгцээ эрс нэмэгдсэн тул бид нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж дүүргийн Эрүүл Мэндийн Төвд 2020 оны 01-р сараас эхлэн шаардлагатай хүчилтөрөгчийг үнэ төлбөргүй үйлдвэрлэн өгсөн байна. Үүнийг компанийн хүчилтөрөгч худалдан борлуулдаг дүнгээр тооцвол 40,0 гаруй сая төгрөг болох юм.





Багануур дүүргийн эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах зорилгоор ЖДҮ-ийг дэмжих төвөөр дамжуулан өвөл, зуны ажлын хувцас, бээлийг хийлгэж эмэгтэйчүүдийнхээ эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлогыг тогтмол хэрэгжүүлдэг.


ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын саналын дагуу “Аварга тосон” нуурын хойд дэнжээр махчин шувууд суух өндөрлөгөт цэг 5 ширхгийг байрлуулан орон нутагт хүлээлгэн өгсөн, Аварга 3-р баг дахь цэцэрлэгт хүрээлэнд 1000ш хайлаас мод тарьсан.

Төв аймгийн Баяндэлгэр сумын “Гүн галуутай” ОНТХГН-т дүйцүүлэн хамгааллаар хийх ажлын төлөвлөгөөнд махчин шувуу суух өндөрлөгөт цэг, хянах байр барьж хүлээлгэн өгсөн.



Монгол улсын Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд цусны нөөц цуглуулалт эрс багасаж, өвчлөл өндөр байгаатай холбогдуулан Уурхайчид бид “НЭГ УУРХАЙЧИН-ГУРВАН ХҮНД АМЬДРАЛ БЭЛЭГЛЭНЭ” аяныг өрнүүлэн нийт уурхайчдын 5% цусаа хандивлалаа.



Баяндэлгэр сумын ЗДТГ-аас өгсөн саналын дагуу махчин шувуу суух өндөрлөгөт цэг 10ш-ийг хийж байрлуулан хянах байрны оронд анхааруулах, таниулах самбар 8ш, хаалт хашлага 1ширхгийг хийж сумын байгаль хамгаалагчид хүлээлгэн өгсөн.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Багануур дүүргийн 4-р хорооны нутагт орших Хайлаастын булгийн эхийг хашиж хамгаалан хүлээлгэн өгсөн.



КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ




Цар тахлын үед яаралтай арга хэмжээг хэрэгжүүлж улсын онцгой комис болон нийслэлийн онцгой комиссын шийдвэрүүдтэй уялдуулан арга хэмжээг авч ажилласан.

Энэ хүрээнд “Багануур” ХК–н гүйцэтгэх захирлын нийт 17 тушаалын дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна.

Ажилтнуудын 98 хувийг коронавирус цар тахлын эсрэг вакцинжуулалтад бүрэн хамрагдуулах ажлыг БНЭМНэгдэлтэй хамтран зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хэт бөөгнөрлийг саармагжуулах зорилгоор ажилтнуудын цайны цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Мөн ажилтнуудад өглөөний цайгаар үйлчлэхийг бүрэн зогсоож, батлагдсан хуваарьт цагийн дагуу халуун дархлаа дэмжсэн хоол ундаар үйлчлэн ажилласан.



Халдвар хамгааллын дэглэмийг чандлан мөрдүүлэх зорилгоор 4 удаагийн хариуцлагатай жижүүрийн баг томилон ажиллуулсан.


Ажилтнуудын урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулан, компанийн хэмжээнд ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийлгэж, амны хаалт, гар ариутгалын бодисоор нийт ажилтнуудаа ханган, шаардлагатай мэдээ мэдээллийг дотоод мэдээллийн сувгаар шуурхай хүргэн ажилласан.





Улс, хот хоорондын авто замын зорчих хөдөлгөөнийг хорьсонтой холбогдуулан ажилдаа ирж чадахгүй хөл хорионд орсон, гэрийн тусгаарлалтад орсон ажилтнуудад үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний олговор олгосон.

Олон нийтийн арга хэмжээ /хурал, цуглаан, сургалт семинар, соёл урлаг, спортын тэмцээн уралдаан/ зохион байгуулахыг хориглож 0–12 насны хүүхэдтэй эхчүүд, ганц бие эцгийг гэрээсээ ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажилласан.



14 хоног тутамд нийт ажлын байрыг ариутган Захиргааны байранд эрүүл бүс байгуулав Автомат халуун хэмжигч, гар ариутгагч, түргэвчилсэн оношлуур үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.


Уурхайн бүс доторх үйлчлэх автобусны цайны цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, ресийн тоог ихэсгэж, 1 автобусанд 15 хүн суухаар төлөвлөлт хийн ажилласан.




КОВИД-19 МЭДЭЭЛЭЛ



1139
Ажилтантай



98%
Вакцинд хамрагдсан



565
Батлагдсан
тохиолдол



Давхардсан тоогоор
1876
тусгаарлалтад



36
Эмнэлэгт хэвтэн
эмчлүүлсэн

* 2021 оны ковидын нөхцөл байдлыг харуулав

Хөнгөн
131

Хүнд
2

Хүндэвтэр
7

Маш хүнд
0

"ХЭМНЭЛТ 2021" АРГА ХЭМЖЭЭ

2021 онд зохион байгуулагдсан "Хэмнэлт 2021" уралдаан зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 19 санал санаачилга ирснээс эхний 6 байр шалгаруулан шагнасан.



1. Зориулалтын засварын машин сэлбэн засварлаж, тоноглох



2. Үйлдвэрийн азотоор технологийн болон бүх төрлийн авто машины дугуй хийлэх санал



3. Гидро экскаваторыг зөөвөрлөх дугуйт ачигч



4. Өрмийн шнек



5. ТАМ-ын ашиглагдсан тосыг дахин цэвэршүүлж, нэмэлтээр ашиглах



6. Багануурын хүрэн нүүрсний ил уурхайн хөрсний дотоод овоолгын тогтворжилтын гулсалт, нуралтын судалгаа, тогтворжилтыг дээшлүүлэх боломжит нөхцөл

2022 оны компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эдгээр шалгарсан саналуудыг хэрэгжүүлэхээр тусгасан.



5 удаагийн шанага үйлдвэрлэл
Хагас тэрбум төгрөгийн бодит хэмнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/613

танай _____ -ны № _____ -г

БАГАНУУР ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Э.НОМИНЧУЛУУН ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Багануур ТӨХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 27 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 142,009.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 141,859.5 сая төгрөгөөр тусгасан байна.

Гүйцэтгэлээр 153,792.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 150,911.1 сая төгрөгийн зардал гарган, 2,881.1 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Багануур ТӨХК-ийн удирдлага 2021 санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу тасралтгүй байх зарчимд тулгуурлан аккурэл сууриар бэлтгэн толилуулсан байна.

Бусад асуудал

Компани 2021 онд техникийн шинэчлэлийн чиглэлээр 12,519.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хийхээр төлөвлөсөнөөс гүйцэтгэлээр 12,396.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийжээ. Мөн Монгол улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны 12.5 сая долларын

Z:\Yawsan_Bichig\2022\0315 Audit\Itin 2 Gazar - 95.Docx

0001050993

хөнгөлөлттэй зээлээр 12 ширхэг техникээр тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэнээр ашиглалтын зардлыг 2,925.0 сая төгрөгөөр бууруулж, технологийн хувьд уурхайн хүчин чадал 500 мян.тн-р нэмэгдэж, жилд 4.5 сая.тн нүүрс олборлох боломжтой болсон байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн тайланд 33 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	703,196,034.90	1,050,042,808.71
1.1.2	Дансны авлага	8,835,659,448.61	8,775,365,449.82
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	316,639,700.00	371,175,156.89
1.1.4	Бусад авлага	54,240,000.00	64,240,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	30,884,314,517.53	32,943,858,583.54
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/гооцоо	6,418,877,568.34	9,323,479,731.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	47,212,927,269.38	52,528,161,730.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	165,059,365,142.15	176,950,745,513.87
1.2.2	Биет бус хөрөнгө	4,834,544,397.25	4,533,635,405.80
1.2.3	Уул уурхайн хөрөнгө/УУ хөгжүүлэлт, хөрс хуулалт/	27,640,437,061.90	27,750,619,346.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	199,298,507,319.64	210,999,160,984.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	246,511,434,589.02	263,527,322,715.31
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	54,087,662,554.73	41,551,861,528.33
2.1.1.2	Цалингийн өглөг	1,736,003,144.00	1,727,755,453.45
2.1.1.3	Татварын өр	30,158,365,547.33	36,418,069,735.09
2.1.1.4	НДШ - ийн өглөг	6,285,057,598.83	10,908,935,599.82
2.1.1.5	Богино хугацаат зээл	47,043,663,499.59	44,886,133,192.80
2.1.1.6	Хүүний өглөг	1,152,844,932.18	1,738,799,203.90
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,971,933.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,075,165,788.45	2,108,794,026.25
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	142,551,734,998.61	139,353,320,673.14
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	23,847,436,176.35	43,410,466,942.54
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	2,203,678,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,847,436,176.35	45,614,144,942.54
2.2	Өр төлбөрийн нийт дүн	166,399,171,174.96	184,967,465,615.68
2.3	Эздийн өмч	2,097,436,000.00	2,097,436,000.00
2.3.1	Өмч:-төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.3	хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	60,685,388,076.98
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,672,308,688.50	7,294,912,713.63
2.3.10	Тусга зориулалтын нөөцийн сан	9,657,130,648.58	8,482,120,309.02
2.3.11	Эздийн өмчийн дүн	80,112,263,414.06	78,559,857,099.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	246,511,434,589.02	263,527,322,715.31

"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	140,370,562,061.13	152,292,931,653.25
2	Борлуулалтын өртөг	128,280,316,426.01	130,809,451,818.36
3	Нийт ашиг(алдагдал)	12,090,245,635.12	21,483,479,834.89
4	Түрээсийн орлого	22,827,202.24	17,478,212.26
5	Хүүний орлого	16,596,136.98	-
6	Ногдол ашгийн орлого	-	4,164,713.64
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	2,601,578,569.01	356,523,350.84
9	Борлуулалт, маркетингийн зардал		669,139,400.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	16,145,317,312.14	10,203,846,720.57
11	Санхүүгийн зардал		1,903,579,779.87
12	Бусад зардал	587,923,734.19	7,325,084,154.34
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	776,207.43	1,121,016,336.81
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(12,358,104.29)	164.48
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,013,575,399.84)	2,881,012,558.13
19	Орлогын татварын зардал	1,659,613.70	1,370,853,622.56
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,015,235,013.54)	1,510,158,935.57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,015,235,013.54)	1,510,158,935.57
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(2,015,235,013.54)	1,510,158,935.57
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00			10,167,616,661.57	12,265,052,661.57
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00			10,167,616,661.57	12,265,052,661.57
Өмчит гарсан өөрчлөлт				1,375,792,150.55	1,375,792,150.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,000,724,576.04)	(2,000,724,576.04)
Зарласан ногдол ашиг					-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	9,657,130,648.58	7,672,308,688.50	80,112,263,414.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,175,010,339.54)	(1,887,554,910.44)	(3,062,565,249.98)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	5,784,753,778.06	77,049,698,164.08
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,510,158,935.57	1,510,158,935.57
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,294,912,713.63	78,559,857,099.63

"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00			10,167,616,661.57	12,265,052,661.57
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00			10,167,616,661.57	12,265,052,661.57
Өмчит гарсан өөрчлөлт				1,375,792,150.55	1,375,792,150.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,000,724,576.04)	(2,000,724,576.04)
Зарласан ногдол ашиг					-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	9,657,130,648.58	7,672,308,688.50	80,112,263,414.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,175,010,339.54)	(1,887,554,910.44)	(3,062,565,249.98)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	5,784,753,778.06	77,049,698,164.08
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,510,158,935.57	1,510,158,935.57
Зарласан ногдол ашиг				-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,294,912,713.63	78,559,857,099.63

"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	142,589,873,234.50	151,077,689,218.70
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	142,303,901,493.49	150,672,159,365.77
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар	250,581,086.42	360,314,075.12
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	35,390,654.59	45,215,777.81
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	107,953,761,972.24	102,705,968,588.73
	Ажиллагчдад төлсөн	30,849,751,113.26	28,802,784,069.99
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,676,337,451.03	5,699,505,515.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	37,536,473,861.15	27,178,814,519.17
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Тулш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,332,491,561.85	27,208,909,872.76
	Хүүний төлбөрт төлсөн	1,054,999,032.11	132,499,856.16
	Татварын байгууллагад төлсөн	10,291,306,443.64	12,414,905,986.43
	Даатгалын төлбөрт төлсөн	7,565,715.00	-
	Бусад мөнгөн зарлага	2,204,836,794.20	1,268,548,769.22
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	34,636,111,262.26	48,371,720,629.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,596,136.98	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	16,596,136.98	-
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,924,919,592.60	39,354,044,407.07
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	26,589,346,904.60	39,320,980,360.07
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	335,572,688.00	33,064,047.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,908,323,455.62)	(39,354,044,407.07)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,350,806,904.97	2,222,492,110.66
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,349,999,834.00	2,222,474,434.00
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	807,070.97	17,676.66
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,412,333,078.70	10,893,321,559.75
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	13,412,302,215.16	10,893,299,263.16
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	30,863.54	22,296.59
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,061,526,173.73)	(8,670,829,449.09)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,333,738,367.09)	346,846,773.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,036,934,401.99	703,196,034.90
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	703,196,034.90	1,050,042,808.71


"Багануур" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт биетээр						
1	Нүүр гаргалт	мян тн	4,050.1	4,000.0	4,341.6	341.6	108.5
2	Нүүрс борлуулалт	мян тн	4,050.5	4,000.0	4,347.7	347.7	108.7
3	Хөрс хуулалт	мян мЗ	17,838.0	17,310.0	19,901.6	2,591.6	115.0
4	Нийт уулын цул	Мян мЗ	30,190.9	26,161.8	31,043.7	4,881.9	118.7
B	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн дүнгээр						
5	Нийт орлого	мян төг	143,011,563.9	142,009,060.7	153,792,114.3	11,783,053.6	108.3
6	Үүнээс: Цэвэр орлого	мян төг	140,370,562.	141,791,337.5	152,292,931.7	10,501,594.2	107.4
B	Нийт зардал	мян төг	145,025,139.4	141,859,544.1	150,911,101.9	9,051,557.8	106.4
7	Ерөнхий ба удирдлагын зардал	мян төг	16,145,317.3	12,439,541.5	10,203,846.7	(2,235,694.8)	82.0
8	Үүнээс: Удирдлагын зардал	мян төг	6,192,223.6	5,704,845.2	8,887,412.2	3,182,567.0	155.8
9	Нийгмийн зардал	мян төг	2,652,319.0	2,509,087.4	2,618,069.0	108,981.6	104.3
Г	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян төг	(2,013,575.5)	149,516.6	2,881,012.6	2,731,495.9	1,926.9
10	Цэвэр ашиг	мян төг	(2,015,235.0)	134,565.0	1,510,168.9	1,375,593.9	1,122.3
11	Төсөвт төлөх нийт төлбөр	мян төг	24,386,168.8	27,344,320.6	32,190,261.1	4,845,940.5	117.7
12	Үүнээс: Орлогын татвар	мян төг	1,659.6	14,951.7	1,370,853.6	1,355,901.9	9,168.5
13	Ажиллагсдын тоо	хүн	1,128.0	1,139.0	1,139.0	-	100.0
14	Цалингийн сан	мян төг	39,625,788.7	38,319,292.2	38,934,167.9	614,875.7	101.6
15	Авлага	мян төг	9,206,539.1	9,113,756.2	9,210,780.6	97,024.4	101.1
16	Өр төлбөр	мян төг	166,399,171.2	181,533,186.1	184,967,465.6	3,434,279.5	101.9
17	Үүнээс: Богино хугацаат өглөг	мян төг	142,551,735.0	113,218,693.7	139,353,320.7	26,134,626.9	123.1
18	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төгрөг	1.0	1.0	1.0	0.0	101.8
19	Хөрөнгө оруулалт	мян төг	34,339,634.9	12,519,550.0	12,396,283.8	(123,266.2)	99.0
20	1тонн нүүрсний өртөг	мян төг	35,807.0	35,464.9	34,759.2	(705.7)	98.0
21	Хөрс хуулалтын коэффициент	мЗ/тн	4.4	4.3	4.6	0.3	105.9
22	Аваар саатал	тоо	-	-	-	-	-
23	Ус шүүрүүлэлт	мян мЗ	5,639.0	5,070.0	5,170.0	100.0	102.0
24	Байгаль орчин шинэчлэлт, иновацийн асуудлыг шийдсэн байдал	мян төг	89,489.8	181,057.9	32,281.4	(148,776.5)	17.8

 (976) - 70210114

 www.baganuurmine.mn

 Улаанбаатар хот, Багануур дүүрэг-12150,
3-р хороо, Багануур хк